



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/088/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 25</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424      Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Нарангэрэл</p> <p>Утас: 99009293      Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.16 № 2/12

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд улсын төсвөөс 2,436,772.4 мянга, орон нутгийн төсвөөс 561,756.2 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 157,617.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,441,404.8 мянга, орон нутгийн төсвөөс 559,718.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 3,095,997.9 мянган төгрөгийг зарцуулж, 2,037.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

**6426050038**

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.0 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>198,852,988.48</u></b>	<b><u>156,732,934.23</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	126,355,449.62	42,119,497.18
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	126,355,449.62	42,119,497.18
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	126,355,449.62	42,119,497.18
31211	Төрийн сангийн харилцах	126,355,449.62	42,119,497.18
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	180,753.19	903,040.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	180,753.19	903,040.08
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	72,316,785.67	113,710,396.97
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	22,718,703.67	40,988,578.97
35110	Тусгай зориулалттай материал	22,540,703.67	40,820,278.97
35130	Эм боох материал	178,000.00	168,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,598,082.00	72,721,818.00
35410	Бичиг хэргийн материал	8,516,080.00	10,292,700.00
35420	Аж ахуйн материал	41,082,002.00	62,429,118.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,965,506,252.44</u></b>	<b><u>5,995,396,585.30</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,965,506,252.44	5,995,396,585.30
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,960,647,919.22	5,829,055,252.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,444,119,600.70	5,444,119,600.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-117,200,000.00	-207,935,326.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	456,855,094.50	496,777,594.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,082,729.80	-223,140,000.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	346,313,695.00	395,255,695.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67,616,311.36	-108,901,459.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,755,100.00	29,302,195.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,636,559.82	-3,253,076.58
39217	Ном	6,140,030.00	6,830,030.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,858,333.22	166,341,333.26
39301	Програм хангамж	6,820,000.00	6,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,961,666.78	-3,501,666.74
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	163,023,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,164,359,240.92</u></b>	<b><u>6,152,129,519.53</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>84,997,000.00</u></b>	<b><u>68,593,152.36</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	84,997,000.00	68,593,152.36
<b>413</b>	<b>Өглөг</b>	84,997,000.00	68,593,152.36
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	17,485,354.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	84,997,000.00	51,107,798.36
41361	Байгууллагад төлөх өглөг	84,997,000.00	49,947,150.36
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,160,648.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,079,362,240.92</u></b>	<b><u>6,083,536,367.17</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,079,362,240.92	6,083,536,367.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	6,079,362,240.92	6,083,536,367.17
51210	Өмнөх үеийн үр дүн	6,079,362,240.92	6,079,362,240.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,174,126.25
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,164,359,240.92</u></b>	<b><u>6,152,129,519.53</u></b>



**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,890,760,929.20</b>	<b>3,279,653,870.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>282,396,429.20</b>	<b>276,492,870.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	282,396,429.20	276,492,870.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	272,444,112.70	252,143,395.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	272,304,112.70	241,505,095.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	9,952,316.50	24,349,475.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,348,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	3,290,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,608,364,500.00</b>	<b>3,003,161,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,057,144,900.00	2,441,404,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,057,144,900.00	2,441,404,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	551,219,600.00	561,756,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	551,219,600.00	561,756,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,711,364,970.79</b>	<b>3,275,479,744.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,711,364,970.79</b>	<b>3,275,479,744.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,684,362,741.32	3,254,838,658.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,574,399,237.10	1,952,784,279.34
210101	Үндсэн цалин	1,574,399,237.10	1,952,784,279.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	197,040,631.72	246,180,456.52
210201	Тэтгэврийн даатгал	135,696,914.72	170,140,741.52
210202	Тэтгэмжийн даатгал	15,624,044.00	19,361,474.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,264,545.00	10,964,460.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,212,557.00	8,239,452.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,242,571.00	37,474,329.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	514,078,520.53	559,874,158.69
210301	Гэрэл, цахилгаан	26,529,480.53	35,962,704.69
210302	Түлш, халаалт	471,416,000.00	502,102,454.00
210303	Цэвэр, бохир ус	16,133,040.00	21,809,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,412,020.50	33,484,604.00
210401	Бичиг хэрэг	9,193,360.00	23,700,080.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,218,660.50	6,337,740.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,696,784.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	96,646,136.00	148,783,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	434,250.00	596,800.00
210502	Хоол, хүнс	96,211,886.00	148,187,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,541,350.00	17,130,000.00
210604	Урсгал засвар	15,541,350.00	17,130,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,455,833.13	33,444,390.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	4,748,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,455,833.13	28,696,090.69
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	248,789,012.34	263,156,969.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,772,500.00	19,922,707.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,287,200.00	00.00

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	207,729,312.34	243,234,262.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,002,229.47</b>	<b>20,641,085.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,561,100.00</b>	<b>18,603,790.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,561,100.00	18,603,790.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>10,441,129.47</b>	<b>2,037,295.31</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,441,129.47	2,037,295.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>179,395,958.41</u></b>	<b><u>4,174,126.25</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>179,395,958.41</u></b>	<b><u>4,174,126.25</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,608,504,500.00</u></b>	<b><u>3,013,799,300.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>140,000.00</b>	<b>10,638,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	140,000.00	10,638,300.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	140,000.00	10,638,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,348,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	3,290,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>2,608,364,500.00</u></b>	<b><u>3,003,161,000.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,057,144,900.00	2,441,404,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,057,144,900.00	2,441,404,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	551,219,600.00	561,756,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	551,219,600.00	561,756,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,509,240,041.14</u></b>	<b><u>3,066,415,752.44</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>2,509,240,041.14</u></b>	<b><u>3,066,415,752.44</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>2,386,025,925.67</u></b>	<b><u>2,897,587,667.13</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,574,453,756.37	1,953,301,129.54
210101	Үндсэн цалин	993,240,971.55	1,159,879,727.47
210102	Нэмэгдэл	523,852,644.82	611,348,185.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	42,850,641.57
210104	Урамшуулал	57,360,140.00	139,222,574.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	197,166,865.64	246,385,893.21
210201	Тэтгэврийн даатгал	134,528,396.54	167,605,688.21
210202	Тэтгэмжийн даатгал	15,742,974.44	19,721,485.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,855,439.51	9,853,322.50
210204	Ажилгүйдлийн даатгал	7,808,130.88	9,841,079.50
210205	Эрүүл мэндийн даатгал	31,231,924.27	39,364,318.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	514,078,520.53	542,588,904.69

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210301	Гэрэл, цахилгаан	26,529,480.53	35,962,704.69
210302	Түлш, халаалт	471,416,000.00	484,817,200.00
210303	Цэвэр, бохир ус	16,133,040.00	21,809,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,699,950.00</b>	<b>17,130,000.00</b>
210604	Урсгал засвар	26,699,950.00	17,130,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,402,666.13</b>	<b>42,311,699.69</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	4,748,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,402,666.13	37,563,399.69
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,224,167.00</b>	<b>95,870,040.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,936,967.00	83,465,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,287,200.00	12,404,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>123,214,115.47</b>	<b>168,828,085.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>112,772,986.00</b>	<b>166,790,790.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	96,211,886.00	148,187,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,561,100.00	18,603,790.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>10,441,129.47</b>	<b>2,037,295.31</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,441,129.47	2,037,295.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>99,264,458.86</b>	<b>-52,616,452.44</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>80,554,800.00</b>	<b>31,619,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>80,554,800.00</b>	<b>31,619,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>80,554,800.00</b>	<b>31,619,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,554,800.00	31,619,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-80,554,800.00</b>	<b>-31,619,500.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>18,709,658.86</b>	<b>-84,235,952.44</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>107,645,790.76</b>	<b>126,355,449.62</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>126,355,449.62</b>	<b>42,119,497.18</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	6,079,362,240.92	6,079,362,240.92
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	6,079,362,240.92	6,079,362,240.92

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>6,079,362,240.92</b>	<b>6,079,362,240.92</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	4,174,126.25	4,174,126.25
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>6,083,536,367.17</b>	<b>6,083,536,367.17</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/**

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,594,390,100.00</b>	<b>2,452,043,100.00</b>	<b>142,347,000.00</b>	<b>94.5</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,436,772,400.00</b>	<b>2,441,404,800.00</b>	<b>-4,632,400.00</b>	<b>100.2</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,436,772,400.00	2,441,404,800.00	-4,632,400.00	100.2
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>157,617,700.00</b>	<b>10,638,300.00</b>	<b>146,979,400.00</b>	<b>6.7</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,148,300.00	7,348,300.00	-200,000.00	102.8
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	126,344,400.00	0.00	126,344,400.00	0.0
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,594,390,100.00</b>	<b>2,536,279,052.44</b>	<b>58,111,047.56</b>	<b>97.8</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,411,542,500.00</b>	<b>2,369,488,262.44</b>	<b>42,054,237.56</b>	<b>98.3</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,985,419,900.00</b>	<b>1,953,301,129.54</b>	<b>32,118,770.46</b>	<b>98.4</b>
Үндсэн цалин	1,244,538,000.00	1,159,879,727.47	84,658,272.53	93.2
Нэмэгдэл	641,871,900.00	611,348,185.64	30,523,714.36	95.2
Унаа хоолны хөнгөлөлт	0.00	42,850,641.57	-42,850,641.57	
Урамшуулал	99,010,000.00	139,222,574.86	-40,212,574.86	140.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>248,177,500.00</b>	<b>246,385,893.21</b>	<b>1,791,606.79</b>	<b>99.3</b>
Тэтгэврийн даатгал	168,760,700.00	167,605,688.21	1,155,011.79	99.3
Тэтгэмжийн даатгал	19,854,200.00	19,721,485.00	132,715.00	99.3
ҮОМШӨ-ний даатгал	9,927,100.00	9,853,322.50	73,777.50	99.3
Ажилгүйдлийн даатгал	9,927,100.00	9,841,079.50	86,020.50	99.1
Эрүүл мэндийн даатгал	39,708,400.00	39,364,318.00	344,082.00	99.1
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>43,207,000.00</b>	<b>42,311,699.69</b>	<b>895,300.31</b>	<b>97.9</b>
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,458,700.00	37,563,399.69	895,300.31	97.7
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>134,738,100.00</b>	<b>127,489,540.00</b>	<b>7,248,560.00</b>	<b>94.6</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	121,709,700.00	114,461,140.00	7,248,560.00	94.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>182,847,600.00</b>	<b>166,790,790.00</b>	<b>16,056,810.00</b>	<b>91.2</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>182,847,600.00</b>	<b>166,790,790.00</b>	<b>16,056,810.00</b>	<b>91.2</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	164,243,800.00	148,187,000.00	16,056,800.00	90.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,603,800.00	18,603,790.00	10.00	100.0
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>126,355,449.62</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>42,119,497.18</b>		

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/**

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>561,756,200.00</b>	<b>559,718,904.69</b>	<b>2,037,295.31</b>	<b>99.6</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>561,756,200.00</b>	<b>559,718,904.69</b>	<b>2,037,295.31</b>	<b>99.6</b>
Орон нутгийн төсвөөс	561,756,200.00	559,718,904.69	2,037,295.31	99.6
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>561,756,200.00</b>	<b>559,718,904.69</b>	<b>2,037,295.31</b>	<b>99.6</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>561,756,200.00</b>	<b>559,718,904.69</b>	<b>2,037,295.31</b>	<b>99.6</b>



**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>544,626,200.00</b>	<b>542,588,904.69</b>	<b>2,037,295.31</b>	<b>99.6</b>
Гэрэл, цахилгаан	38,000,000.00	35,962,704.69	2,037,295.31	94.6
Түлш, халаалт	484,817,200.00	484,817,200.00	-	100.0
Цэвэр, бохир ус	21,809,000.00	21,809,000.00	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,130,000.00</b>	<b>17,130,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Урсгал засвар	17,130,000.00	17,130,000.00	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>65</b>	<b>65</b>	<b>0</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	40	40	0	100.0
Үйлчлэх ажилтан	24	24	0	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь “Сургуулийн менежментийг сайжруулан чанартай сургалтаар чадварлаг, зөв хандлагатай сурагчдыг хамтын оролцоотойгоор төлөвшүүлнэ” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас тус байгууллагын 2023-2024 оны хамруулан хяналт, шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар нийт 79,452.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3,117.1 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн төлбөрийн акт тогтоож, 48,055.0 төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 28,280.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,229.7 мянган төгрөг буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	1	2	3	4	5	6
<b>А</b>						
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	198,853.0	3.2%	156,732.9	2.5%	(42,120.1)	-21.2%
Мөнгөн хөрөнгө	126,355.4	2.0%	42,119.5	0.7%	(84,236.0)	-66.7%
Авлага	180.8	0.0%	903.0	0.0%	722.3	399.6%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	72,316.8	1.2%	113,710.4	1.8%	41,393.6	57.2%
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	5,965,506.3	96.8%	5,995,396.6	97.5%	29,890.3	0.5%
Үндсэн хөрөнгө	6,269,003.5	101.7%	6,542,128.1	106.3%	273,124.6	4.4%
Хуримтлагдсан элэгдэл	(303,497.3)	-4.9%	(546,731.5)	-8.9%	(243,234.3)	80.1%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,164,359.2</b>	<b>100.0%</b>	<b>6,152,129.5</b>	<b>100.0%</b>	<b>(12,229.7)</b>	<b>-0.2%</b>
Өр төлбөр	84,997.0	1.4%	68,593.2	1.1%	(16,403.8)	-19.3%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,079,362.2	98.6%	6,083,536.4	98.9%	4,174.1	0.1%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,164,359.2</b>	<b>100.0%</b>	<b>6,152,129.5</b>	<b>100.0%</b>	<b>(12,229.7)</b>	<b>-0.2%</b>

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 42,119.5 мянган төгрөг байгаа нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 903.0 мянга буюу 722.3 мянган төгрөгөөр өссөн нь татварын байгууллагад илүү шилжүүлсэн ХХОАТ-ыг тайлагнасанатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 113,710.4 мянган төгрөг болж 41,393.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 216,485.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 18,279.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 6,069.9 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 196,744.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,696.9 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж устгасан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,542,128.1 мянган төгрөг болж 273,124.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 31,619.5 мянга, аймгийн орон нутгийн

хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13,585.0 мянган төгрөгийн өртөг бүхий урлагийн заалны хөшиг, мотор, 7,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 75 инчийн ухаалаг самбар, ӨТБХ төрийн бус байгууллагын хандиваар 12,719.9 мянган төгрөгийн өртөг бүхий зоорь, 7,827.1 мянган төгрөгийн өртөг бүхий хүлэмж, иргэний хандиваар ирүүлсэн 26,640.0 мянган төгрөгийн өртөг бүхий 24 ширхэг гүйдэг самбар, Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 10,710.0 мянган төгрөгийн өртөг бүхий 15 ширхэг сургалтын ТАВ, мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дүгээр тогтоолоор 163,023.0 мянган төгрөгийн өртөг бүхий газрыг аймгийн Боловсролын газраас балансаас балансад шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,083,536.4 мянган төгрөг болж 4,174.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 4,174.1 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ны 1320.0 мянган төгрөгийн өртөг бүхий Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тайлант онд лицензийн төлбөрт 440.0 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна.

Мөн Боловсролын ерөнхий газраас нийлүүлсэн элсэлтийн ерөнхий шалгалтын хариу засах 5,500.0 мянган төгрөгийн өртөг бүхий программыг сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,080,444.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,080,444.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 75,702.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,156,146.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,325,736.4 мянган төгрөгийн төсөв баталсан ч 2025 оны 12 дугаар сард төсвийг тодотгон 2,594,390.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2,441,404.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,536,279.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,536,279.1 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 32,118.8 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,791.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

үйлчилгээний төлбөр хураамж 895.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 7,248.6 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 16,056.8 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/ төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	<b>71802 Ерөнхий боловсрол</b>	<b>2,594,390,100.00</b>	<b>2,536,279,052.39</b>	<b>239,400.00</b>	<b>98.1</b>
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,708,000.00	3,708,000.00	0.00	100.0
2	80233 Хүүхэд хамгаалал	3,814,000.00	3,574,600.00	239,400.00	93.7
3	80312 Сургалт семинар	2,042,500.00	2,042,500.00	0.00	100.0
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,909,100.00	3,909,100.00	0.00	100.0
5	81801 Үдийн цай хөтөлбөр	164,243,800.00	148,187,000.00	16,056,800.00	90.2
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	61,421,300.00	61378800	42,500.00	99.9
7	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшл	7,193,900.00	7193200	700.00	100.0
8	81834 Боловсролын стандарт, сургалты	2,167,323,600.00	2147333379	19,990,220.80	99.1
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	135,135,300.00	134889533.5	245,766.50	99.8
10	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	26,525,000.00	5884640	20,640,360.00	22.2
11	81848 Сурах бичгийн тірээс	4,748,300.00	4748300	0.00	100.0
12	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	14,325,300.00	13429999.69	895,300.31	93.8

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 561,756.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 561,756.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 542,588.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 17,130.0 мянган төгрөгийг зарцуулж, 2,037.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Тус байгууллагын төсөвт хоолны хөнгөлөлтийг батлаагүй бөгөөд Боловсролын ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 дугаар албан бичгийг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/15 дугаар тушаалаар нэг хүний 5.0 мянган төгрөгөөр тооцож нийт 42,850.6 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг цалингийн зардлаас олгосон байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Ц.Мөнх-Эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Анхтуяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан нийт төсөвт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөвт зардал 3,156,146.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,561.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 20,515.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,037.3 мянга буюу 0.4%-иар хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 32,304.9 мянган төгрөгийн 1 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 85,388.7 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит ХХК-ын аудитор О.Мандах гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчилд 1,544.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025.05.12-ний өдрийн 105 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт				0	0
Албан шаардлага	1	1,544.0	1	1,544.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	1	1,544.0	1	1,544.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын төсөвт хоолны зардлыг батлаагүй цалингийн зардлын хэмнэлтээс олгож байгаа тул төсвийн шууд захирагчийн төсөвт тус зардлыг төлөвлөн батлуулж олгох шаардлагатай тул аймгийн Боловсролын газарт зөвлөмжийг хүргүүлэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,471.4 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны нярвын хүнсний тайлан санхүүгийн тайлангаас 4,471.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, УСНББОУС-12 Бараа материал, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 46,254.5 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>2</sup> илэрснээс 34,199.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 12,055.1 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг алдаа зөрчил буюу 30,635.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 925.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Ур чадварын нэмэгдлийг олгохдоо Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 дүгээр тушаалаар баталсан шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 дүгээр тушаалаар баталсан “Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийн 4.4 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж үнэлж олгодог байх, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.2 Байгууллага нь илүү цагийн нэмэгдлийг олгохдоо төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмыг зөрчиж 4,245.0 мянган төгрөгийг хэтрүүлэн олгосон, үндсэн ажлаас өөр ажил гүйцэтгүүлж илүү цаг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 1.4-д “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно”, 3.3 “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид илүү цагийн нэмэгдлийг олгохдоо нэмэгдэл хөлс олгох журмыг баримтлан, зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.3 Тус байгууллага нь хичээл практикийн зардлыг төлөвлөх, зарцуулахдаа Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 2.6-д заасны дагуу бичгийн хэрэгсэлд 40 хүртэл хувийг зарцуулах байтал 13,028.4 мянган төгрөг буюу 100 хувь төлөвлөж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 2.6 “Хичээл практикийн зардлыг доор дурдсан зориулалтад заасан хувь хэмжээг баримтлан зарцуулахаар тооцож төлөвлөлт хийнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах зааврыг баримтлан журамд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, зарцуулан алдаа, зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.4 Хүүхэд хамгааллын зардлаас олимпиадын хүүхдүүдийн шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар”-ын 2.5 дахь заалтыг зөрчиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар”-ын 2.5 “Сургуулийн хүүхэд хамгааллын зардалд дараах үйл ажиллагааны зардал багтана” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид дээрх зардлыг зарцуулахдаа хүүхэд хамгааллын багийн жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн журамд заасны дагуу зарцуулан алдаа, зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.5 Цахим хэрэглээний зардлаас 3,6,11 дүгээр саруудад байгууллагын суурин утасны төлбөрт 307.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журам”-ын 2.1 “Цахим хэрэглээний

зардал нь Засгийг газрын тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүнд”-нд заасан хувь хэмжээгээр тодорхойлогдоно. Цахим хэрэглээний зардлыг интернэт үйлчилгээ, цахим систем, цахим эрх гэсэн сонголттойгоор төлөвлөн зарцуулах боломжтой” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдын цалингаас хөдөлмөрийн тухай хууль зөрчиж хамтын сангийн 12,055.1 мянган төгрөгийг суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ажилчдын цалингаас хуульд зааснаас бусад хэлбэрээр суутгал хийдэг байдлыг таслан зогсоож зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Тайлант хугацааны нярвын хүнсний тайлан санхүүгийн тайлангаас 4,471.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	1	4,471.4	1	4,471.4			1	4,471.4		
Дүн	1	4,471.4	1	4,471.4			1	4,471.4		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг олгохдоо Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 дүгээр тушаалаар баталсан шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй олгосон байна.	1	15,618.6			1	15,618.6		
Байгууллага нь илүү цагийн нэмэгдлийг олгохдоо төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмыг зөрчиж хэтрүүлэн олгосон, үндсэн ажлаас өөр ажил гүйцэтгүүлж илүү цаг олгосон байна.	1	4,245.0			1	4,245.0		
Ажилчдын цалингаас хөдөлмөрийн тухай хууль зөрчиж хамтын сангийн 12,055.1 мянган төгрөгийг суутгасан байна.	1	12,055.1					1	12,055.1
Тус байгууллага нь хичээл практикийн зардлыг төлөвлөх, зарцуулахдаа Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан "Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 2.6-д заасны дагуу бичгийн хэрэгсэлд 40 хүртэл хувийг зарцуулах байтал 13,028.4 төгрөг буюу 100 хувь төлөвлөж, зарцуулсан байна.	1	13,028.4			1	13,028.4		
Цахим хэрэглээний зардлаас 3,6,11 дүгээр саруудад байгууллагын суурин утасны төлбөрт 307409 төгрөг төлсөн нь Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журам"-ын 2.1 дэх заалтыг зөрчиж байна.	1	307.4			1	307.4		
Хүүхэд хамгааллын зардлаас олимпиадын хүүхдүүдийн шатахууны зардалд 1,000,000 төгрөгийг зарцуулсан нь Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан "Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар"-ын 2.5 дахь заалтыг зөрчиж байна.	1	1,000.0			1	1,000.0		
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>46,254.5</b>			<b>5</b>	<b>34,199.4</b>	<b>1</b>	<b>12,055.1</b>

-----oOo-----

